

**“Батлан хамгаалах салбарт жендэрийн талаар баримтлах бодлого”-ыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд 2023 оны жилийн эцсийн байдлаар хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тухай танилцуулга**

*Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго*

Батлан хамгаалахын сайдын 2020 оны А/300 дугаар тушаалаар батлагдсан Батлан хамгаалах салбарт жендэрийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг үнэлэх, удирдлагад үнэн зөв мэдээлэл өгч, биелэлтийг хангахад дэмжлэг үзүүлэхэд хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго оршино.

*Хоёр: Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй*

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгож, Стратегийн бодлого, төлөвлөлтийн газраас ирүүлсэн тайланг нягтлан үзэх, хариуцсан албан тушаалтнаас тодруулга авч, цуглуулсан мэдээллийг нэгтгэн дүгнэх, дүн шинжилгээ хийх замаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, хэрэгжилтийг хувиар илэрхийлсэн болно.

*Гурав: Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн:*

Батлан хамгаалах салбарт жендэрийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлж, харьяа агентлаг, аж ахуйн нэгж байгууллагын салбар, дэд зөвлөлийн үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах, жендэрийн талаарх ойлголт, хандлагыг өөрчлөх, манлайллыг бий болгох замаар жендэрийн ялгаварлан гадуурхалт, жендэрт суурилсан аливаа хүчирхийллээс ангид байх орчинг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд тус бодлогын баримт бичгийг зорилго чиглэж, дараах үр дүнд хүрэхээр төлөвлөн ажиллаж байна.

- Батлан хамгаалах салбарт жендэрийн талаар баримтлах бодлого хэрэгжиж, салбар зөвлөлийн үйл ажиллагаа боловсронгуй болж, удирдлагын харилцан ажиллагаа дээшлүүлэх;
- Жендэрийн талаарх ойлголт, хандлагыг өөрчлөх, манлайллыг бий болгох замаар жендэрийн ялгаварлан гадуурхалт, жендэрт суурилсан аливаа хүчирхийллээс ангид ажлын орчинг бүрдүүлэх зохион байгуулалт сайжруулах.

Батлан хамгаалах салбарт жендэрийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 3 зорилт, 61 заалтыг хяналтад авч хэрэгжилтийг ханган ажилласны биелэлтийг зорилт тус бүрээр хувиар илэрхийлэхэд:

д/д	Төлөвлөгөөний зорилт	Нийт арга хэмжээ	Үнэлгээ /хувиар/						Нийт үнэлгээ
			100	90	70	50	30	0	
1	Зорилт 1. Салбарын хөгжлийн бодлого, төлөвлөлт, үйл ажиллагаа, хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээнд жендэрийн мэдрэмжтэй болгох арга зүйг нэвтрүүлэх;	29	20	-	6	2	-	1	86.6
2	Зорилт 2. Салбарын хэмжээнд хүйсээр ангилсан статистик мэдээллийг бүрдүүлэх, ашиглах чадавхыг дээшлүүлэх, жендэрийн	13	4	7	-	-	-	2	79.2

	ялгаварлан гадуурхалт, жендэрт суурилсан аливаа хүчирхийллээс ангид ажлын орчныг бий болгох								
3	Зорилт 3. Жендэрийн хэвшмэл ойлголт, тэгш байдлыг хангах талаарх мэдлэг, чадварыг дээшлүүлж, хүний нөөцийг сургаж бэлтгэх	19	6	9	2	1	1	-	85.7
4	Нийт	61	30	16	8	3	1	3	84.9

Хэрэгжилт хангалтгүй буюу 0-50 хувийн хэрэгжилттэй дараах арга хэмжээг эрчимжүүлж ажиллах шаардлагатай байна. Үүнд:

д/д	Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилтийн явц
1	Хүүхэд асрах чөлөөтэй байгаа эмэгтэй алба хаагчдад “Гэр цэцэрлэг хөтөлбөр”-т хамрагдах бололцоог судлан шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх	1.5.2. “Гэр цэцэрлэг хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх  1.5.3 Хүүхэд асрах чөлөөтэй байгаа эмэгтэйчүүдийг онлайн сургалтаар мэргэжил, мэдлэгээ дээшлүүлэх боломжоор хангах	Жилд 1-ээс доошгүй байгууллага хэрэгжүүлсэн байх  20-оос доошгүй хүүхэд асрах чөлөөтэй эмэгтэй хамрагдсан байх	Хэрэгжүүлэх талаар ямар нэг арга хэмжээ зохион байгуулаагүй.  Цэргийн төв эмнэлгийн хүүхэд асрах чөлөөтэй байгаа эмч, сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүдийг багц цагийн болон мэргэжлийн чиглэлийн цахим сургалтад тогтмол хамруулж, эмчлэх, сувилах, эрхийн зөвшөөрөл сунгах, хувь хүний болон мэргэжлийн мэдлэгээ дээшлүүлэх боломжийг бүрдүүлэн 30 алба хаагчийг хамруулсан.
2	ЦТЭ болон хугацаат цэргийн алба хаагчтай анги, байгууллагын эмнэлгийн нэгжид нийгмийн эрүүл мэндийн ажилтны хүний нөөцийг нэмэгдүүлэх, шаардлагатай техник, тоног төхөөрөмж, табель хэрэгслээр хангахад дэмжлэг үзүүлэх	1.9.2. Шаардлагатай техник, тоног төхөөрөмж, табель хэрэгслээр хангахад дэмжлэг үзүүлэх	-	Байгууллагын нийгмийн эрүүл мэндийн ажилчид нь “Цэргийн албыг зохион байгуулах заавар”-ын дагуу зохион байгуулсан анги, тэнхим, өрөөнд ажиллаж байна.
3	Салбарт ажиллаж буй нийт бие бүрэлдэхүүний эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгэм, соёл, эдийн засгийн идэвхтэй оролцоо, гэр бүлд	2.4.1. Салбарт ажиллаж буй нийт бие бүрэлдэхүүний эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгэм, соёл, эдийн засгийн идэвхтэй оролцоо, гэр бүлд	Судалгааны 1-ээс доошгүй.	2022,2023 оны төсвийн саналд “Батлан хамгаалах салбарт жендэрийн бодлого”-ын хэрэгжилтийг хангахаар судалгаа явуулах,

	тулгамдаж буй асуудалд судалгаа явуулах, зөвлөмж боловсруулж, хэрэгжүүлэх	тулгамдаж буй асуудалд судалгаа явуулах 2.4.2. Судалгааны ажлын үр дүн, зөвлөмжийг хэрэгжүүлэх	Судалгааны үр дүнг ашиглана, зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна.	зөвлөмж боловсруулах зорилгоор 10 сая төгрөгийн төсвийн саналыг явуулсан боловч тухайн зардал дэмжигдээгүй, төсөвт суугаагүй тул уг ажлыг 2024 он хүртэл хойшлуулсан.
4	ҮБХИС-ийн сонсогч, оюутан, сурагч, хугацаат, гэрээт цэргийн алба хаагчдыг жендэрийн хэвшмэл ойлголт, ажлын байран дахь бэлгийн дарамт, жендэрийн ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх, жендэрт суурилсан аливаа хүчирхийллээс ангид байх зэрэг асуудлаарх сургалтад хамруулж, сурталчлан таниулах	3.5.1.Сургалтын хөтөлбөр батлагдсан байна.	ҮБХИС-ийн захирлаар батлуулсан тусгай төлөвлөгөөний дагуу сургалтыг зохион байгуулж байна.	Сургалтын төлөвлөгөөнд тусгаагүй.
5	Үр хүүхдээ эх оронч үзэлтэй, хөдөлмөрч, шударга, ёс суртахуунтай иргэн болгон төлөвшүүлэн хүмүүжүүлж байгааг цэргийн алба хаагч, ажилтны гэр бүлийг хамт олны дунд сурталчлах ажлыг зохион байгуулах	3.8.2 Батлан хамгаалах Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн , цэрэг дайчид, сонсогч оюутнуудын дунд “Гэр бүлийн үнэ цэнэ” сэдэвт өдөрлөг уулзалтыг жилд 2 удаа зохион байгуулах	Жилд 2 удаа зохион байгуулах	2023 оны 05 дугаар сарын 31-ний өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор ЗХЖШ, Монгол цэргийн холбоо хамтран Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан “Энхийг сахиулагч ээж” сэдэвт гэр бүлийн өдөрлөгийг зохион байгуулсан.

#### Дүгнэлт, зөвлөмж:

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу Батлан хамгаалахын сайдын 2020 оны А/300 дугаар тушаалаар батлагдсан Батлан хамгаалах салбарт жендэрийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, 84.9 хувь буюу ”тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэлээ.

Тус төлөвлөгөөнд тусгагдсан 61 арга хэмжээнээс хэрэгжүүлэхэд төсөв хөрөнгө шаардлагатай арга хэмжээнд шаардагдах санхүүжилтийг Батлан хамгаалахын сайдын 2024 төсөвт тусгуулах, удирдлага зохион байгуулалтаас шалтгаалан 2023 оны зорилтот түвшинд хүрээгүй арга хэмжээг 2024 онд бүрэн хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.